МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 12 өдөр Дугаар 238 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14.2.10 дах заалт, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратеги"-ийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үнэлгээний удирдамжийг хоёрдугаар, үнэлгээний төлөвлөгөөг гуравдугаар, үнэлгээ хийх хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. "Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратеги"-ийн үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлөөр 2015 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080825

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 12 өдрийн
238 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Оюунсүрэн, Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Н.Цогзолмаа, ЭМСЯ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
Гишүүд:	М.Уранчимэг, ЭМСЯ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэслтийн дарга
	Д.Уранчимэг, ЭМСЯ, Эм, эмнэлгийн хэрэгслийн хэслтийн мэргэжилтэн
	Г.Цэцэнсанаа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмийн зохицуулалтын албаны дарга
	З.Хулан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмийн зохицуулалтын албаны Эмийн тандалт судалгааны асуудал хариуцсан мэргэжилтэн
	Ч.Отгонцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч /зөвшилцсөнөөр/
	Н.Гэрэлт-Од, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч /зөвшилцсөнөөр/
	Н.Рэнцэн-Амгалан, “Эм холбоо”-ны тэргүүн

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06. сарын 12. өдрийн
238. дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

"ХУУРАМЧ ЭМТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ"-ИЙН ТӨГСГӨЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

Үндэслэл

Монгол улсын эрүүл мэндийн салбарыг 2005-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайдын 2010 оны 269 дугаар тушаалаар Хуурамч эмтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг батласан. Хөтөлбөрийг 5 жил хэрэгжүүлж үйл ажиллагааны хэрэгжилт болон санхүүгийн зарцуулалтанд үнэлгээ хийхээр 2015 оны төлөвлөгөөнд туссан.

Зорилго

Хөтөлбөрийн эмийн талаар мөрдөх хууль эрх зүйн орчин, лабораторийн хүчин чадлыг сайжруулах, олон нийтэд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн боловсронгуй болгох үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийх

Үйл ажиллагаа:

1. Үнэлгээний ажлын хэсэг байгуулах, арга хэмжээний үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулах, үйл ажиллагааны үр дүнгийн САР үнэлгээ хийх асуумжийг боловсруулах
2. Боловсруулагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу нийслэлийн 2 дүүрэг, 2 аймагт томилолтоор ажиллах
3. "Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратеги"-ийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний зөвлөлдөх уулзалт зохион байгуулах
4. Үнэлгээний тайланг гаргаж Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах

Үнэлгээ хийх хугацаа:

2015 оны 05 сарын 18-ээс 09 сарын 15-г хүртэл

Санхүүжилт:

ДЭМБ (ДЭМБ-ын төлөвлөгөөний 4.3.3 С3 11.2)

Гарах үр дүн:

Стратегийн хэрэгжилтийн үр дүнг тооцно.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 12. өдрийн
238. дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

"ХУУРАМЧ ЭМТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ"-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУВААРЬ

№	Үйл ажиллагаа	6 сар	7 сар	8 сар	9 сар
1	Ажлын хэсгийн тушаал батлах, ажлын хэсгийн нэгдсэн хурал зохион байгуулах				
2	Үнэлгээний санхүүжилт, хөдөө орон нутгийн хуваарь гаргах				
3	Нэгдсэн үнэлгээ хийх аргачлал гаргах, үнэлгээ хийх				
4	Орон нутагт үнэлгээ хийх				
5	Үнэлгээний дүнг нэгтгэх				
6	ЭМСЯ-ны УЗ-ийн хуралд танилцуулах				
7	"Хуурамч эмтэй тэмцэх үндэсний стратеги"-ийн зөвлөлдөх уулзатыг зохион байгуулах				